



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 8 сарын 28 өдөр

Дугаар 238

Улаанбаатар хот

Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд  
өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 04 дүгээр тогтоолоор баталсан “Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай үйл ажиллагааны багц дүрэм”-ийн нэгдүгээр хавсралт “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 6.12 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монсек ҮЦК” ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 141,600,000 /нэг зуун дөчин нэгэн сая зургаан зуун мянга/ төгрөгөөр нэмэгдүүлж хавсралтад заасны дагуу хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулахыг зөвшөөрсүгэй.

2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг ажлын 15 хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэхийг “Монсек ҮЦК” ХХК /М.Отгонбаатар/-д үүрэг болгосугай.


3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН

Санхүүгийн зохицуулах хорооны  
2019 оны 3 дугаар сарын 26-ны  
өдрийн 258-р тогтоолын хавсралт



“Монсек ҮЦК” ХХК-ийн хувь нийлүүлсэн  
хөрөнгийн хэмжээнд оруулах өөрчлөлт

| № | Хувьцаа<br>эзэмшигчийн нэр,<br>/Регистрийн дугаар/ | Хувьцааны<br>нэрлэсэн<br>үнэ/₮/ | Хувьцааны эхний үлдэгдэл |                    |                      | Өөрчлөлт        |               |                 | Хувьцааны эцсийн<br>үлдэгдэл |                    |                |
|---|--|---------------------------------|--------------------------|--------------------|----------------------|-----------------|---------------|-----------------|------------------------------|--------------------|----------------|
|   |  |                                 | Тоо<br>ширхэг            | Үнийн<br>дүн/₮/    | Эзлэх<br>хувь<br>/%/ | Нэрлэсэн<br>үнэ | Тоо<br>ширхэг | Үнийн<br>дүн/₮/ | Тоо<br>ширхэг                | Үнийн дүн/₮/       | Эзлэх хувь /%/ |
| 1 | М.Отгонбаатар<br>/ЧК71081279/                      | 1,000                           | 258,400                  | 258,400,000        | 100                  | 1,000           | 141,600       | 141,600,000     | 400,000                      | 400,000,000        | 100            |
|   | Нийт   | 1,000                           | <b>258,400</b>           | <b>258,400,000</b> | <b>100</b>           | <b>1,000</b>    | 141,600       | 141,600,000     | <b>400,000</b>               | <b>400,000,000</b> | <b>100</b>     |